

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Л. Дамба	Дугаар	L261
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Баянцагаан сум
Төрсөн газар	Баянцагаан сум	Төрсөн он	1927
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дарьгиатын хийд	Сүм хийдийн дугаар	ТӨБЦ 002
Одоогийн сүм хийд	Зогсоодын хүйс хийд	Сүм хийдийн дугаар	ТӨБЦ 003
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 13	Ярилцлага авсан хүн	Жужа



Төв аймгийн Баянцагаан сумын Дарьгиатын жас Л. Дамба

Жужа: Та шавилан сууж байсан Дарьгиатын хийдийн тухай ярьж өгөхгүй юу?

Дамба: Шавилах ч юу байхав, жаахан хүүхэд ном заалгаж байсан юм.

Жужа: Хэдэн лам хэдэн дугантай байсан бэ?

Дамба: Аа мэдэхгүй, 10-аад өвгөчүүл нэг л дугантай байсан.

Жужа: Суварга байсан уу?

Дамба: Суварга байгаагүй.

Жужа: Нийт ламын тоо ер нь хэд байсан юм бол?

Дамба: Ер нь л арваас давахгүй байсан байх.

Жужа: Хэдэн жастай байсан бэ?

Дамба. Нэг л жастай байсан.

Жужа: Тэр ганц дуган нь модон дуган байсан уу?

Дамба: Аан ер нь л модон дуган байсан байх. Дугуй модон дуган л байсан.

Энхбаяр: Тэр гэрийн буурь шиг туурь дуганы туурь уу?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

1

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамба: Тийм, тэр дуганы туурь. Та нар тэрүүгээр орсон юм уу?  
Жужа: Яг тэр газрын нэр юу вэ?  
Дамба: Бурхант гэдэг газар.  
Жужа: Аль овоогоо тахидаг байсан бэ?  
Дамба: Аа тэрүүхэн баруунтай Мандал овоо гэж овоо бий. Түүнийг тахидаг байсан.  
Жужа: Тэнд ямар нэг худаг ус бий юу?  
Дамба: Нэлээн баруунтай тэр Мандал овоог тойроод Хөх хошуу гэж ус бий.  
Жужа: Тийшээ Манхан уул гэж байдаг уу?  
Дамба: Манхан уул гэж бий. Тэр туурийн чинь баруун өмнөхөн баруун, зүүн Манхан гэж хоёр Манхан уул бий.  
Жужа: Хийдийн хамба ямар хүн байв?  
Дамба: Магсар гэж лам байсан.  
Жужа: Хамба уу, ловон уу ямар хэргэмтэй хүн байв?  
Дамба: Хамба нь байсан байх аа. Миний л багш байсан. Би хүүхэд байхдаа ном заалгаж байсан юм.  
Жужа: Гол шүтээн ямар сахиустай байсан бэ?  
Дамба: Мэдэхгүй ээ. Гомбо, махгал л байсан юм байж дээ.  
Жужа: Лам нар тогтмол тэнд байдаг уу, аль эсвэл хөдөөнөөс ирдэг байсан уу?  
Дамба: Голдуу л тэндээ суудаг байсан. Тогтмол л хуралтай байсан болохоор.  
Жужа: Ямар ямар хурал хурдаг байсан юм бол?  
Дамба: тэрнийг бол ёстой мэдэхгүй. Юу юу хурдаг байсан юм, цогчин лав хурдаг байсан.  
Жужа: Энэ жасын ойролцоо өвөр 3 жас гэж байсан уу?  
Дамба: Байсан. Өвөр гурван жас гэж нэг дугантай жас байсан юм.  
Жужа: Өвөр гурван жас танай харъяа байсан уу, тусдаа байсан уу?  
Дамба: Үгүй манайхаас тусдаа бие даасан жас байсан.  
Жужа: Тэр Өвөр гурван жас хуучин засаг захиргааны бүтцээр Дайчин бэйсийн хошуунд орох уу, Цэцэн вангийн нутагт орох уу?  
Дамба: Дайчин бэйсийн хошуунд орохгүй юм аа. Цэцэн вангийн хошуундаа л орох болов уу.  
Жужа: Өөр энэ хавьд Дэлгэр Өлзийтийн хурал гэж байсан уу?  
Дамба: Байсан юм, энэ хойшоо .  
Жужа: Эндээс хол уу?  
Дамба: 30-аад км орчимд хойшоогоо туурь нь байгаа.  
Жужа: Дарьгиатын жас хэдэн онд хаагдсан юм бэ?  
Дамба: Мянга есөн зуун гучин хэдэн он, би ч 13 хүрээгүй л байсан. 1927 оноос хойш 1937, 1938 оны үед юм уу, тэр орчимд хаагдсан.  
Жужа: Та хэдэн онд шавилах болсон юм бэ?  
Дамба: 6, 7-тойдоо суугаад л 4 жил суусан.  
Жужа: Дарьгиатын жасд гэсгүй байсан юм уу?  
Дамба: Байлгүй яахав, нэг гэсгүй байсан.  
Энхбаяр: Том лам нар 10 орчим байсан, хүүхэд багачууд хэд орчим байсан юм бэ?  
Дамба: 3-4 хүүхэд л байсан.  
Жужа: Ганжуур байсан уу?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

2

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамба: Мэдэхгүй ээ, тогтмол хуралтай байсныг бодоход байсан юм байлгүй.

Жужа: Та хэдэн онд дахиад лам болсон бэ?

Дамба: Би одоо бол лам биш, хүүхэд байхдаа ном үзэж байгаад л тэрнээс хойш таг хаясан.

Жужа: Дарьгиатын жасад сууж байсан өөр лам нар одоо бий юу?

Дамба: Байхгүй, байхгүй.

Энхбаяр: Яг одоо лам байгаагүй ч энэ хавийн жас хурлуудын тухай мэдэх тийм настай хүмүүс байна уу?

Дамба: Байхгүй ээ, одоо ч ховордож. Уг нь та нар сайхан судалгааны ажил хийж байгаа юм байна.

Даанч оройтож, настай хүмүүс нь үнэхээр мэдэх хүмүүс нь одоо ховордчихсон.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 3